

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд^{1/} МУЗЗНДНТУтХ/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 5 зүйлтэйгээр боловсруулсан.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-3 дахь заалтаар МУЗЗНДНТУт хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтад “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх” гэсэн заалт нэмэхээр тусгасан талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр МУЗЗНДНТУт хуулийг шинэчлэн найруулсан бөгөөд уг шинэчилсэн найруулгаар орон нутгийн чиг үүргийн давхардлыг арилгаж, баг, сум, аймаг, хороо, дүүрэг, нийслэлийн иг үүргийг зааглан, улмаар тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх, үүргийг тухайн шатны засаг даргад тусгайлан олгосон байдаг. Энэ хүрээнд:

1.1.МУЗЗНДНТУт хуулийн 60 дугаар зүйлд Аймгийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

1.2.МУЗЗНДНТУт хуулийн 62 дугаар зүйлд Дүүргийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд дүүргийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

1.3.МУЗЗНДНТУт хуулийн 63 дугаар зүйлд Нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг тогтоож өгсөн заалтууд дунд нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх эрхийг шинээр тусгаж өгөхөөр төсөлд тусгав.

2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд тухайн хуульд нэмэлтээр оруулсан заалтын улмаар хуулийн зарим заалтын дугаар өөрчлөгдөж буй талаар:

2.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21-д “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны

¹ 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэх дагаж мөрдсөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/16106891904801>

дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 60.1.21 дэх заалтын дугаарыг "60.1.22" гэж,

2.2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13-д "Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 62.1.13 дахь заалтын дугаарыг "62.1.14" гэж,

2.3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.13-д "Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;" гэсэн заалт нэмэлтээр орж байгаа тул өмнө байсан 63 дугаар зүйлийн 63.1.13 дахь заалтын дугаарыг "63.1.14" гэж, 63.1.14 дэх заалтын дугаарыг "63.1.15" гэж, 63.1.15 дахь заалтын дугаарыг "63.1.16" гэж тус тус өөрчилсөн.

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан талаар:

Хуулийн төсөлд Засаг даргад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрхийг олгосноор өмнөх удирдлага жилийн үйл ажиллагааны тайланг тавих, ажил үүргээ дүгнүүлэх боломжийг олгох үүднээс хууль батлагдсаны дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөхөөр тусгалаа.

Нэг.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.",

Тавин ёсдүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.", Жаран нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна.", Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.", Жаран хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно." гэж тус тус заасан.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.2 дахь зорилтыг хэрэгжүүлэх I үе шатанд "I үе шат (2021-2030): Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн

хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе.” хэсгийн 2 дахь заалтад “Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оновчтой хуваарилалт бий болж, орон нутгийн бие даасан байдал хангагдана” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 онд хийгдсэн бөгөөд уг шинэчилсэн найруулгаар засаг захиргааны нэгж, нутгийн удирдлагын чиг үүргийг тодорхойлж, улмаар чиг үүргийг давхардалгүй, хийдэлгүй тодорхойлсны дээр нутгийн удирдлагын чиг үүргээс гадна төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэхээр мөн хуульд тодорхой зааж өгсөн байдаг.

Иймд орон нутаг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцах хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг удирдлагаар хангах, тэдний ажлын хариуцлагыг ч мөн өөрөө давхар хариуцахаар хуульчлагдсан. Иймээс харьяа нутаг дэвсгэртээ төрийн чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд Засаг дарга нь засаг төрийн төлөөлөгчийн хувьд өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагыг томилж чөлөөлөх, хариуцлага тооцох, ажлын төлөвлөлт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, чадварлаг төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, урьж ажиллуулах зэргээр удирдлага, зохион байгуулалтын эрхийг нь мөн шилжүүлж өгөх шаардлага үүсч байгаа болно.

Иймд орон нутгийн удирдлагад өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагын томилгоог хийх боломжийг холбогдох хууль тогтоомжид тусгаж өгөх, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд шаардлагатай нэмэлт оруулах явдал болно.

Хоёр.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6-11 дүгээр зүйлд засаг захиргааны нэгжийг тодорхойлж, тухайн засаг захиргааны нэгжийн орон нутгийн чиг үүргийг 20 дугаар зүйлд, мөн нэгж бүрээр зааглан 21-26 дугаар зүйлд тус бүр нарийвчлан давхардалгүйгээр тодорхойлж өгснө байдаг. Ингэхдээ чиг үүргийг а). Эдийн засаг, төсвийн талаар орон нутгийн чиг үүрэг, б). Бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх талаарх орон нутгийн чиг үүрэг, в). Зохицуулалтын шинжтэй чиг үүрэг, г). Үйлчилгээ, аж ахуйн талаарх орон нутгийн чиг үүрэг гэсэн 4 хүрээнд тусгайлан тодорхойлсон байдаг.

Төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бодлого хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээ, аж ахуйн талаарх чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлдэг агентлагуудын удирдлагын томилгоог орон нутаг, засаг даргад шилжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Иймээс төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх агентлагуудын орон нутаг дахь байгууллагын захирал, удирдлагуудыг томилох, чөлөөлөх эрхийг хуулиар Засаг даргад олгох асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тусгах, салбарын хуулиудад зааж өгөх зохицуулалтыг энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгалаа.

Гурав.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын удирдлагыг томилохтой холбогдсон харилцааг хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгтэй холбоотой харилцааг тусгайлан зохицуулахаар тусгаж, 27 дугаар зүйлийн 27.5-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлнэ:” гэж холбогдох чиг үүргүүдийг жагсааж өгсөн байдаг.

Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн дараагаар Засгийн газраас Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог баталж, улмаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагуудыг жагсаалтаар баталж өгсөн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох” тухай 37 дугаар тогтоолоор аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 газар, хэлтсийг тогтоож өгчээ.

Харин тухайн агентлагуудын удирдлагын томилгоог салбарын хуулиудад төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын удирдлагын эрх, үүрэгт хамааруулан холбогдох хэсэг, заалтаар зааж өгсөн байдаг.

Дөрөв.Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын гишүүд санаачлан УИХ дахь Ардчилсан намын бүлэг, Монгол ардын намын бүлгийн зарим гишүүдэд хуулийн төслийн үзэл баримтлалыг танилцуулж улмаар УИХ-ын гишүүд хамтран ажиллаж, олон нийт, орон нутгийн засаг захиргааны нэгжийн удирдлагуудын хүрээнд удаа дараагийн хэлэлцүүлэг зохион байгуулав.

Мөн хуульд зааснаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн хэрэгцээ шаардлага болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний ажилд мэргэжлийн хуульч, судлаачидтай гэрээ байгуулан хамтран ажилсан болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60, 62, 63 дугаар зүйлд тухайн шатны засаг даргын эрх, үүргийн хэсэгт нэмэлт оруулах замаар засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, удирдлагыг томилох зохицуулалтыг тусгаж өгч байгаа болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60, 62, 63 дугаар зүйлд оруулж буй нэмэлт:

1/60 дугаар зүйлийн 60.1.21 дахь заалт:

“60.1.21.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

2/62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт:

“62.1.13.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

3/63 дугаар зүйлийн 63.1.13 дахь заалт:

“63.1.13.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн дарга, удирдлагыг хуульд заасны дагуу томилж чөлөөлөх;”

Тав.Дагах хуулиудын танилцуулга

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Засаг даргын томилгооны эрх үүссэнтэй холбоотойгоор засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагааг зохицуулсан салбарын хуулиад дахь томилгооны заалтуудыг өөрчлөн найруулах замаар томилох субъектыг өөрчилж төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын даргын эрх мэдлээс Засаг даргад шилжүүлсэн зохицуулалтыг бий болгож байна.

Салбар хуулиудад оруулж буй нэмэлт, өөрчлөлт болох хасах зуултууд нь дараах 3 онцлог шинжийг агуулж байгаа болно.

1.Тухайн хуульд аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг зохицуулаагүй тохиолдолд орон нутгийн байгууллагын удирдлагыг томилохдоо тухайн засаг захиргааны нэгжийн засаг даргын санал болгосноор төрийн захиргааны төв /төрийн захиргааны/ байгууллага томилж, чөлөөлөх

2.Тухайн хуульд аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрхийг зохицуулсан зүйл байгаа тохиолдолд орон нутгийн байгууллагын удирдлагыг томилохдоо төрийн захиргааны төв /төрийн захиргааны/ байгууллагын удирдлагын эрх, үүрэг хэсгээс холбогдох заалтыг хасаж, тухайн шатны засаг даргын эрх, үүрэгт нь томилж, чөлөөлөх зохицуулалтыг тусгаж өгч байгаа болно.

3.Хэрэв тухайн салбарын хуулинд орон нутгийн байгууллагын удирдлагыг томилж чөлөөлөх зохицуулалтыг төрийн захиргааны төв /төрийн захиргааны/ байгууллагын ч, тухайн шатны засаг даргын ч эрх, үүрэгт бус ерөнхийдөө тухайн агентлагийн удирдлагын тогтолцоо хэсэгт тусгасан зохицуулалт байвал уг хэсэг, заалтыг шууд өөрчлөн найруулах замаар зохицуулалтыг шинээр тусгаж байгаа болно.

Энэ хүрээнд дараах хуулиудын холбогдох хэсэг, заалтуудыг өөрчлөн найруулж, зарим хуульд нэмэлт оруулж байгаа болно. Үүнд:

1.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
26.1.18.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;	"26.1.18. аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, хуульд заасны дагуу чөлөөлөх;"

2.Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
35.3.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.	"35.3.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө;"

3.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга;	"28.7.2.энэ хуулийн 28.3-т заасан байгууллагын захирлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын даргыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга;"

4.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
24.3.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.	"24.3. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг хуульд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийслэлийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө;"

5.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
18.2.Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг аймаг, нийслэлийн	"18.2. Аймаг, нийслэлийн соёлын газрын удирдлагыг соёлын асуудал

Засаг даргатай зөвшилцөн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.	эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө;"
--	--

6.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Одоо хүчин төгөлдөр байгаа хэсэг, заалт	Өөрчлөн найруулах төсөл
32 ¹ .4.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог баталж, нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн даргыг томилж, чөлөөлнө.	"32 ¹ .4. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог баталж, нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн даргыг тухайн шатны Засаг даргын санал болгосноор томилж, чөлөөлнө;"

7.Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Хасах заалт

1/11 дүгээр зүйлийн 11.2. дахь хэсэг:

"11.2.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засаг даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын даргыг томилж, чөлөөлнө;"

Нэмэх заалт

"13.1.5.Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллагын даргыг томилж, чөлөөлнө;"

Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлд заалт шинээр нэмж байгаатай холбоотойгоор хуулийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг дараах байдлаар өөрчилсөн болно.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын дугаарыг "13.1.6" гэж, 13.1.6 дахь заалтын дугаарыг "13.1.7" гэж, 13.1.7 дахь заалтын дугаарыг "13.1.8" гэж, 13.1.8 дахь заалтын дугаарыг "13.1.9" гэж, 13.1.9 дэх заалтын дугаарыг "13.1.10" гэж, 13.1.10 дахь заалтын дугаарыг "13.1.11" гэж, 13.1.11 дэх заалтын дугаарыг "13.1.12" гэж тус тус өөрчилсүгэй.

---oOo---